



# ХӨСӨГ ТРЕЙД

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сар 20 өдөр

№ 04

Улаанбаатар хот

Г Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Г  
төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан  
дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46.6 болон 62.1.9 дэх заалт, “**ХӨСӨГ ТРЕЙД**” ХК-ийн 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
2. Компани 2022 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг танилцуулсныг дурдсугай.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



С.БОЛОР



# ХӨСӨГ ТРЕЙД

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 1 сар 20 өдөр

№ 02

Улаанбаатар хот

Г Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг  
батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62.1.1 дэх заалт, “ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн одоо эрхэлж байгаа “авто замаар ачаа тээвэрлэх үйлчилгээ”, “автомашинны засвар үйлчилгээ”, “гадаад дотоод худалдаа”, “зочид буудал, цайны газар” гэх үйл ажиллагааны чиглэлүүдийг хасаж “үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх” чиглэлийг дүрэмд нэмснийг дурдсугай.
2. “Хөсөг трейд” ХК-ийн дүрмийг энэхүү шийдвэрийн Хавсралт 1-ээр шинэчлэн баталсугай.
3. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /М.Эрдэнэсүх/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



С.БОЛОР